


**“ЗАГАС ЗАГАСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД
ЦӨӨРМИЙН АЖ АХУЙГ МОНГОЛД ХӨГЖҮҮЛЭХ” ТСР/MON/3501
ТӨСЛИЙН 2015 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2016 оны жилийн эцсийн байдлаар)**

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл		
1	“Загас, загасан бүтээгдэхүүний нийлүү-лэлтийг нэмэгдүүлэхэд цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх” ТСР/MON/3501 төсөл	Загасны туршилтын аж ахуйн үйл ажиллагааг дэмжиж Монгол улсын хүн амын хүнсний хэрэгцээнд биологийн төгс тэжээллэг чанартай загас, загасан бүтээгдэхүүн нийлүүлэх боломжийг нэмэгдүүлэх; Монгол улсад загасны салбар хөгжих тааламжтай орчинг бүрдүүлэх үндсэн чадавхийг бий болгох;		
2	Санхүүжилтийн эх үүсвэр	НҮБ, ХХААБ		
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих хугацаа	Хүнс, хөдөө аж ахуйн яам ХААИС-ийн Мал Аж Ахуй Биотехнологийн сургууль НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, “Хилэм Ост” загасны аж ахуй “Жижиг горхи” загасны аж ахуй		
	Хэрэгжих хугацаа:	2014.03.01 - 2016.02.01		
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Загасны аж ахуйн хөгжлийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх; Зорилт 2. Монгол улсад загасны аж ахуйг хөгжүүлэх боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх; Зорилт 3. Бүрэн нарийвчилсан техникийн шийдлийг боловсруулж, сонгогдсон хоёр загасны аж ахуйн үйл ажиллагаанд нь нэвтрүүлэх; Зорилт 4. Загасны аж ахуйн үйл ажиллагаа, хөгжлийг дэмжихэд нэн шаардлагатай чадавхийг бий болгох;		
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	268 000 ам.доллар	
		Үүнд :	Гүйцэтгэл	Хувь
		2014 он	118 104	44.1
		2015 он	48 470	18.1
2016 он	101 426	37.8		
6	Хөтөлбөрийн зорилт :	Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ.		
	Зорилт 1. Загасны аж ахуйн хөгжлийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх	<p><u>Шалгуур үзүүлэлт 1.1.</u> Загасны аж ахуйтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүд боловсрогдсон байна. Төслийн хүрээнд НҮБ-ын ХХААБ-аас хуулийн үндэсний зөвлөхийг сонгон шалгаруулсан. Хуулийн үндэсний зөвлөх нь Монгол улсад загасны аж ахуйг хөгжүүлэх хууль эрх зүйн орчинг судлаж, зөвлөмж боловсруулсан. <i>ХШҮ- 70%</i></p> <p><u>Шалгуур үзүүлэлт 1.2.</u> Загасны аж ахуйг хөгжүүлэх талаар баримтлах төрийн бодлого стратеги боловсрогдон, шийдвэр гаргах зохих шатны төрийн байгууллагад танилцуулагдсан байна. <i>ХШҮ-0%</i></p> <p><u>Шалгуур үзүүлэлт 1.3.</u> Хүн амын хүнс, эрүүл мэндэд загас, загасан бүтээгдэхүүний хэрэглээний ач холбогдлын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт дээшилсэн байна. 2014 оны 4 сарын 7-ны өдөр Үйлдвэр Хөдөө Аж Ахуйн Яаманд “Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд, цөөрмийн аж ахуйг монголд хөгжүүлэх” төслийн нээлтийн семинарыг зохион байгуулав. Нээлтийн ажиллагаанд ҮХААЯ, НҮБ-ийн ХХААБ, Химийн хүрээлэн, Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Хувийн аж ахуй нэгж, хувь хүмүүсээс бүрдсэн 30 гаруй хүн оролцов. Тайлант хугацаанд “Загас хамгаалах клуб”-ийн фэйсбүүк хуудсанд загасан бүтээгдэхүүний ач тус, хэрэглээний талаар 13 удаагийн зар, мэдээлэл, сурталчилгаа байрлуулсан. Төслийн хэрэгжилтийг таниулах, сурталчлах зорилгоор Болор телевизтэй хамтран ажиллаж “ХАА-н цаг” нэвтрүүлэгт 4 удаа танилцуулга хийсэн. <i>ХШҮ- 90%</i></p>		

<p><u>Зорилт 2.</u> Монгол улсад загасны аж ахуйг хөгжүүлэх боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх</p>	<p><u>Шалгуур үзүүлэлт 2.1.</u> 1. Монгол орны нөхцөлд тохирсон загасны аж ахуйн технологийн дадлагад 20 хүн сургасан байна. 2. “Хүйтэн усны загас үржүүлэг”-ийн сургалт 2014 оны 4 сарын 9-11-ны өдрүүдэд Үйлдвэр Хөдөө Аж Ахуйн Яаманд (ҮХААЯ)-д амжилттай зохион байгуулсан бөгөөд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуй нэгж, судлаач оюутнуудаас бүрдсэн 32 хүн хамрагдсан болно. 3. БНХАУ-ын Харбин хотноо 2014 оны 10 сарын 9-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Хүйтэн усны загас үржүүлгийн сургалт семинарт “Хилэм Ост” загасны аж ахуй, “Жижиг горхи” загасны аж ахуйн ажилтан 3 хүнийг хамруулав. Энэхүү сургалтаар загасны аж ахуйн удирдлага зохион байгуулалт, усжуулалтын систем, цөөрмийн бүтэц зохион байгуулалт, загасны тэжээл, тэдгээрийн норм, загасны өвчин, халдварт болон халдваргүй өвчиний тархалт, тэдгээрээс сэргийлэх, эмчлэх, загас үржүүлэх аргууд, арчилгаа маллагаа зэргийн талаар олон улсын зөвлөхүүд хичээл заасан бөгөөд сургалтын үеэр нэмэлт мэдээлэл болон тайлбаруудыг хийв. 4. “Өмнөд өмнөдийн хамтын ажиллагаа (ӨӨХА) хөтөлбөрийн хүрээнд БНХАУ-тай хамтран Монгол Улсын “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийг дэмжих техник туслалцаа” ТСР/MON/010/CPR төсөлтэй хамтран Сэлэнгэ аймагт 2015 оны 5 сард 14 хоногийн хугацаатай ХААИС-ийн Мал Аж Ахуй Биотехнологийн сургуулийн загасны аж ахуйн ангийн 14 оюутанд загас үржүүлгийн практик дадлагын сургалт хийж тэдэнд загасны төрөл зүйл, өсөлт, хөгжилт, өвчний талаар нарийвчлан зааж сургасан. 5. “Хилэм ост” загасны аж ахуйд Хилэм (<i>Sturgeon</i>) загасны жараахайг хүлээн авах бэлтгэл ажлыг (2015.06.13-06.26) төслийн зөвлөхүүдээс зааварчилгаа аван хангасан. Уг загасны аж ахуйд 6000 ширхэг жарамгай хүлээн авч, зөвөөрлөн шилжүүлэх ажил 2015.06.27-ны өдөр Mr Cao Guangbin-ний удирдлаган доор зохион байгуулалттай хийгдэж жарамгайд үхэл хорогдол гаралгүй 100% мэнд үлдсэн. Хилэм (<i>Sturgeon</i>) загасны жараахайг хооллон 10-15 хоног тутам хяналтын жин авч тэжээлийн норм, хэмжээг тогтоож байсан ба 56 хоногийн турш /2015.08.21 хүртэл/ тэжээхэд биеийн дундаж урт нь 9-28.3 см-т хүрч, биеийн дундаж жин 3.5-64.6 гр болж тус тус өссөн. Энэ хугацаанд жараахайн нийт хорогдол нь 523 буюу 8.71% байв.</p>  <p>Мөн “Хилэм Ост” загасны аж ахуйд ажиллах хугацаанд ХААИС-ийн МАА биотехнологийн сургуулийн Загас үржүүлэг, технологи мэргэжлийн ангийн 12 оюутанг үйлдвэрлэлийн дадлагад хамруулж, усны температурыг тогтмол хугацаанд хэмжих, загасны тэжээлийн хоногийн нормыг тогтоох, үхэл хорогдол тооцох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн тусгай хяналтын дэвтэрт бүртгэлжүүлсэн.</p> <p style="text-align: right;"><i>ХШҮ- 100%</i></p> <p><u>Шалгуур үзүүлэлт 2.2.</u> БНХАУ-ын сэрүүн бүсийн загасны судалгаа, сургалтын байгууллагад загасны аж ахуйн технологийн чиглэлээр мэргэжлийн 2-3 хүнийг сургасан байна. БНХАУ-ын Харбин хотноо 2014 оны 10 сарын 9-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Хүйтэн усны загас үржүүлгийн сургалт семинарт “Хилэм Ост” загасны аж ахуй, “Жижиг горхи” загасны аж ахуйн ажилтан 3 хүнийг хамруулав.</p> <p style="text-align: right;"><i>ХШҮ-100%</i></p>
---	--

Шалгуур үзүүлэлт 2.3. Загас, цөөрмийн аж ахуй дээр 8-10 ажилтанг загасны аж ахуйн технологи, менежментийн чиглэлээр сургагдсан байна. “Хилэм Ост” загасны аж ахуйд загас үржүүлгийн чиглэлээр ажилладаг үндсэн 2 ажилтан, менежер нь жарамхай өсгөх хугацаанд загасны аж ахуйн технологи, менежментийн чиглэлээр суралцсан.



“Хилэм ост” загасны аж ахуйд Хилэм-*Sturgeon* загасны 6000 ширхэг жарамгай хүлээн авч, зөвлөхүүдийн заавар зөвлөмжийн дагуу 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдрөөс 2015 оны 8 дугаар сарын 21 өдөр хүртлэх хугацаанд байгууллагын мэргэжилтэн, удирдлагуудтай хамтран загасыг арчилах, тэжээх, өсгөх болон бусад шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэв. Мөн “Хилэм Ост” загасны аж ахуйд ажиллах хугацаанд Загас үржүүлэг, технологи мэргэжлийн ангийн оюутануудтай хамтарч усны температурыг тогтмол хугацаанд хэмжих, загасны тэжээлийн хоногийн нормыг тогтоох, үхэл хорогдол тооцох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн тусгай хяналтын дэвтэрт бүртгэлжүүлсэн.

Тайлант ажлын хугацаанд ХААИС-ийн загас үржүүлгийн лаборатори байгуулах газрын талаар сургуулийн удирдлагуудтай санал солилцон, төлөвлөсөн барилга байгууламжын план зураг, бусад шаардлагатай материалыг цаг тухайд бэлтгэн зөвлөхүүдэд танилцуулсан. Жижиг горхи загасны аж ахуйн Тул-*Huchotaimen* загасны жараахай хүлээн авах зарим бэлтгэл ажилд Загас үржүүлэг, технологи мэргэжлийн ангийн оюутнуудыг удирдан 8-9 дүгээр саруудад 8 хоногийн хугацаанд оролцсон. Тайлант хугацаанд хийсэн ажлуудыг дараах байдлаар харуулав(*Хүснэгт-1*).

Хүснэгт-1

Date	Хийсэн ажил	Хамран оролцсон хүмүүс
June 10, 2015	1. “KhilemOst” aquaculture farm site (Visited) 2. “Little River” aquaculture farm site(Visited)	<ul style="list-style-type: none"> • Project’s LTO Mr Miao Weimin, • AFAOR MsNyamjargal G, • NPC MsTsetsegdari Ts. , • NC for cold water fish farm and hatchery facility design and engineering MrMunkhgerel N • Ms.Tsengel.Ts
June 11, 2015	Animal Science and Biotechnology of Mongolian University of Life Science(Visited)	<ul style="list-style-type: none"> • Project’s LTO Mr Miao Weimin, • AFAOR MsNyamjargal G, • NPC MsTsetsegdari M., • NC for cold water fish farm and hatchery facility design and engineering MrMunkhgerel N • Ms.Tsengel
June 12, 2015	Төслийн дунд шатны хэлэлцүүлэг	<ul style="list-style-type: none"> • Төслийн баг
June13-14, 2015	“KhilemOst” aquaculture farm site(Visited)	<ul style="list-style-type: none"> • TCDC consultant Mr Wang Bingqian, • TCDC consultant Mr Cao Guangbinm • NC for cold water fish farm and hatchery facility design and engineering Munkhgerel N • Ms.Tsengel

		June 15-16, 2015	“KhilemOst” aquaculture farm site(Visited) Animal Science and Biotechnology of Mongolian University of Life Science (Visited)	<ul style="list-style-type: none"> • TCDC consultant Mr Wang Bingqian, • TCDC consultant Mr Cao Guangbinm • NC for cold water fish farm and hatchery facility design and engineering Munkhgerel N • Ms.Tsengel
		June 17, 2015	“Little River” aquaculture farm site(Visited) “KhilemOst” aquaculture farm site(Visited)	<ul style="list-style-type: none"> • TCDC consultant Mr Wang Bingqian, • TCDC consultant Mr Cao Guangbinm • NC for cold water fish farm and hatchery facility design and engineering Munkhgerel N • Ms.Tsengel
		June 18-29, 2015	“KhilemOst” aquaculture farm site(Visited) Хилэм загасны жарамгай хүлээн авсан.	<ul style="list-style-type: none"> • TCDC consultant Mr Wang Bingqian, • TCDC consultant Mr Cao Guangbinm • SSCMr.Zhao • NC for cold water fish farm and hatchery facility design and engineering Munkhgerel N • Ms.Tsengel
		July 9-23, 2015	“KhilemOst” aquaculture farm site(Visited) Загасны жарамгай арчилж малласан.	<ul style="list-style-type: none"> • Student Jansag, Erdenetseseg, Navaan
		August 1-5, September 3-7 2015	Animal Science and Biotechnology of Mongolian University of Life Science Загас үржүүлэг, технологи мэргэжлийн бакалавр болон магисрын хөтөлбөр боловсруулсан.	ХААИС - Загас үржүүлэг технологи мэргэжлийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлж батлуулсан
		August 5-8, 2015	Animal Science and Biotechnology of Mongolian University of Life Science Загас үржүүлгийн лаборатори байгуулах барилгын план зураг боловсруулсан.	
		August 11-19, 2015 September 11-13, 015	“Little River” aquaculture farm site(Visited) Загас хүлээн авах бэлтгэл ажилд оролцсон.	ХААИС-Загас үржүүлэг технологи мэргэжлийн ангийн оюутнууд
		October 11-13, 2015	Animal Science and Biotechnology of Mongolian University of Life Science Загас үржүүлгийн лаборатори байгуулах барилгатай танилцан, план зураг хийсэн.	
<p>Мөн жараахайг хүлээн авснаас 1 сарын хугацаанд /2016 оны 6 сарын 26-аас 7 сарын 26-ыг хүртэл/ ХААИС-ийн багш, 3 оюутан байнга ажилласан.</p> <p style="text-align: right;"><i>ХШҮ- 90%</i></p>				

<p>Зорилт 3. Сонгогдсон 2 загасны аж ахуйд тохирсон техникийн шийдлийг гарган үйл ажиллагаанд нь нэвтрүүлэх</p>	<p>Шалгуур үзүүлэлт 3.1. Сонгогдсон АА-д зориулалтын битүү байранд загас үржүүлэх эргэлтийн систем, хайрцагласан тортой систем болон гадна цөөрөмд загас үржүүлэх, барих тоноглолын техникийн дэлгэрэнгүй загвар боловсрогдсон байна (Улаанбаатар хот орчимд - Туул голын сав газарт болон хайрга олборлолтоос үүссэн нуур)</p> <ul style="list-style-type: none"> • “Хилэм ост” / Туул голын сав дагуу УБ хотоос доош 43 км/ аж ахуйд загас үржүүлгийн барилгын зураг төслийн дагуу битүү дээвэртэй 500м² талбайтай барилгыг барив. Барилгын дулааны асуудлыг шийдвэрлэхээр 800м² талбайг халаах хүчин чадалтай халаалтын төхөөрөмжийг Унгар улсаас захиалан авсан. • “Жижиг горхи” / Туул голын сав дагуу УБ хотоос дээш 65 км/ аж ахуйд загас үржүүлгийн барилгын зураг төслийн дагуу 500м² талбайтай барилга барив. • “Хилэм Ост” загасны аж ахуйд 2 эгнээ, эгнээ бүр 6 торон хашаанаас бүрдэх, нийт 12 торон хашаа бүхий гадна цөөрмийн усан сан байгуулсан. Мөн TCDC зөвлөх Mr Wang Bingqian, Mr Cao Guangbin нарын зааварчилсан “Хилэм Ост” загасны аж ахуйн цөөрмийн план зургийг зуран барилгын ажил гүйцэтгэгч нарт хүлээлгэн өгсөн.  <p style="text-align: right;"><i>ХШҮ- 90%</i></p> <p>Шалгуур үзүүлэлт 3.2. Сонгогдсон 2 аж ахуйн үйл ажиллагаа амжилттай явагдах нөхцлийг бүрдүүлэх техник туслалцааг үзүүлэхийн зэрэгцээ эдгээр аж ахуйд үйлдвэрлэлийн түлхүүр үйл ажиллагаанд нэн шаардлагатай зарим тоноглолыг төслөөс санхүүжүүлэн худалдан авч нийлүүлсэн байна. Сонгогдсон 2 аж ахуйд тус бүр 15.000 ам долларын төсөвт багтаан дараах тоног төхөөрөмж, материал авахаар төлөвлөсөн.</p> <ul style="list-style-type: none"> • “Жижиг горхи” аж ахуйд Үр тогтсон өндөг өсгөвөрлөх инкубатор /hatching jar 12 ш, 4 tray vertical incubator 1/ Тулын нүдэн жарамгай -20 мянга, Жарамгайн хоол, тэжээл. <p>“Жижиг горхи” загасны аж ахуйн Тул-<i>Huchotaimen</i> загасны жарамгай /15.000 ам.доллар/ хүлээн авах бэлтгэл ажлыг хангах зорилгоор цөөрмийн аж ахуйн талбайд цэвэрлэгээ хийх, мод бутыг янзлах, талбайд мал орохоос хамгаалж торон хашаа хатгах, барилгын цонх, шал угаах, цэвэрлэх зэрэг ажлуудыг хийсэн. Цаг улирал, цөөрмийн бэлэн байдал зэргээс шалтгаалан гадна орчинд жарамхай өсгөх боломж хараахан бүрдээгүй тул хугацааг хойшлуулсан.</p> <ul style="list-style-type: none"> • “Хилэм ост” аж ахуйд Хилэм, солонгон хулдын жарамгай, Цөөрмийн ажиглалт, судалгаанд зориулагдсан завь. <p>“Хилэм ост” ХХК нь 2015.06.27-нд төслийн хүрээнд 6000 жарамхайг хоол тэжээлийн хамт /20.000 ам.доллар/ хүлээн авсан хэдий ч технологийн буруутай үйлдлээс хорогдсон.</p> <p style="text-align: right;"><i>ХШҮ- 90%</i></p>
<p>Зорилт 4. Загасны аж ахуйн үйл ажиллагаа, хөгжлийг дэмжихэд нэн шаардлагатай чадавхийг бий болгох.</p>	<p>Шалгуур үзүүлэлт 4.1. ХААИС-д загасны аж ахуйн хүрээлэн буй орчныг хянах, загасны өвчин эмгэгийг оношлох загас судлалын лаборатори байгуулагдаж, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.</p> <p>Мал аж ахуй биотехнологийн сургуулийг түшиглэн баригдах загас үржүүлгийн лабораторийн план зургийг гарган төслийн зөвлөхүүдэд илгээсэн боловч газрын асуудлаас шалтгаалан баригдах боломжгүй болсон учир шинээр лаборатори байгуулах боломжтой барилгын план зураг болон бусад холбогдох зургуудыг дахин гаргасан.</p> <p>Цэвэр усны эх үүсвэр бүхий 150 м² лабораторийн байрыг бэлтгэж</p>

		<p>ашиглалтад оруулсан. Төслийн хүрээнд нийт 60000 ам. долларын өртөг бүхий лабораторийн тоног төхөөрөмжийг худалдан авч, суурилуулах ажлыг хийж байна.</p> <p style="text-align: right;"><i>ХШҮ- 100%</i></p> <p><u>Шалгуур үзүүлэлт 4.2.</u> Монгол оронд тохирсон загас үржүүлгийн технологийн гарын авлага боловсрогдсон байна.</p> <p>ХХААБ-ын загасны аж ахуй ба загас үржүүлгийн техникийн баримт бичгийн “Цэвэр усанд, торонд сибирийн хилэм үржүүлэх арга техникийн гарын авлага”-ыг зөвлөх, мэргэжилтэнүүд бэлтгэн орчуулав.</p> <p>“Өмнөд өмнөдийн хамтын ажиллагаа (ӨӨХА) хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийг дэмжих техник туслалцаа” GCP/MON/010/CPR төслийн зөвлөхтэй хамтран “Загасны аж ахуй эрхлэгчдэд зориулсан гарын авлага”-ыг боловсруулж, хэвлэлтэд бэлэн болгосон. Энэхүү гарын авлага нь 2017 оны 4 дүгээр сард хэвлэгдэж гарна.</p> <p style="text-align: right;"><i>ХШҮ- 100%</i></p>				
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Төслийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг зорилтын шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд дунджаар 85,0 хувьтай дүгнэгдсэн ба 2015 онд нийт санхүүжилтийн 18.1 хувь буюу 48470 ам.доллар, 2016 онд 101426 ам.доллар зарцуулсан байна.</p> <p><u>Ололт:</u></p> <p>-Монгол оронд хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан үйлдвэрийн аргаар боловсруулсан загасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, загасны аж ахуй хөгжих үндсийг тавьж, үйл ажиллагааг эхлүүлсэнд оршино.</p> <p>-Загасны аж ахуйн мэргэжилтэн бэлтгэх, байгууллагын болон хүний нөөцийн чадавхи бүрдүүлэхэд төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа чухал /загасны аж ахуйн технологийн дадлага/ нөлөө үзүүлж байна.</p> <p><u>Дутагдал:</u></p> <p>-Цөөрмийн аж ахуйг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор НҮБ-ын ХХААБ-аас үндэсний зөвлөх тусгайлан шалгаруулан гэрээ байгуулсан хэдий ч үйл ажиллагааны стратеги боловсруулах ажил хангалтгүй байв.</p> <p>-Монгол орны байгаль, цаг уурын онцлог болон аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хүндрэлээс шалтгаалан хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаа нь худалдан авах ажиллагаа хойшлогдож, төслийн үр дүнд нөлөөлж байна.</p> <p>-Төлөвлөсөн үр дүнд бүрэн хүрэхэд хамтран хэрэгжүүлэгч талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхгүй байх, ажлын тайланг хугацаанд ирүүлэхгүй байх дутагдал ажиглагдаж байв.</p> <p><u>Анхаарах асуудал:</u></p> <p>-Төслийн хүрээнд тоног төхөөрмж, туршлага дамжуулж авсан, хүний нөөц нь чадавхижсан сургууль болон аж ахуйн нэгжүүд загас судлал ба үйлдвэрлэл, цөөрмийн аж ахуйн үйл ажиллагаагаа өргөтгөх, зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэх шаардлагатай.</p> <p>-Загас, загасан бүтээгдэхүүний хэрэглээний ач холбогдлын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх.</p>				
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо харьцангуй сайжирсан.				
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Дундаж үнэлгээ, (%)	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
		85.0	53.3	96.6	90.0	100.0
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ, %				